



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Г Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчтэй хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 201 дугаар тушаал, "Дэлгэрхангай секьюритиз" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай 2014 оны 12 дугаар сар 11-ний өдрийн 41 тоот болон 2014 оны 12 дугаар сар 15-ны өдрийн 45 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дэлгэрхангай секьюритиз" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчтэй хувьцаат компанийн байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Дэлгэрхангай секьюритиз" ХХК /М.Бат-Оргил/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР